



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ГАЛУУТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/99/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал.....	19
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

ГАЛУУТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ЦЭГМИД ТАНАА

2021.02.18 № 2/55
танай _____ -ны № _____ -т
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

2021 A4 TOOT

005 005020891

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

0	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,179,383.00</u>	<u>120,374,526.00</u>
33	АВЛАГА	441,272.00	12,860,664.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	441,272.00	47,664.00
335	Бусад авлага	00.00	12,813,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	12,813,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	70,738,111.00	107,513,862.00
351	Түүхий эд материал	00.00	996,400.00
35130	Эм боох материал	00.00	996,400.00
354	Хангамжийн материал	70,738,111.00	106,517,462.00
35410	Бичиг хэргийн материал	2,529,180.00	1,101,780.00
35420	Аж ахуйн материал	60,554,581.00	88,222,582.00
35450	Барилгын засварын материал	5,207,650.00	13,209,850.00
35460	Хүнсний материал	2,446,700.00	2,250.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	3,981,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,545,407,727.54</u>	<u>1,720,551,324.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,545,407,727.54	1,720,551,324.10
392	Биет хөрөнгө	1,507,293,256.82	1,682,459,113.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,367,163,240.00	1,564,327,979.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,606,590.12	-36,074,770.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,000,000.00	28,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-2,799,999.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	142,232,721.27	171,220,573.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-94,958,322.50	-118,380,969.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	146,091,352.22	155,179,852.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-78,180,362.25	-89,360,789.85
39217	Ном	8,551,218.20	10,347,238.20
393	Биет бус хөрөнгө	38,114,470.72	38,092,210.72
39301	Программ хангамж	352,600.00	352,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-238,129.28	-260,389.28
39303	Бусад биет бус хөрөнгө	38,000,000.00	38,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,616,587,110.54</u>	<u>1,840,925,850.10</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>150,000.00</u>	<u>610,761.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	150,000.00	610,761.00
413	Өглөг	150,000.00	610,761.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	150,000.00	610,761.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,616,437,110.54</u>	<u>1,840,315,089.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,616,437,110.54	1,840,315,089.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,308,640,649.12	1,308,640,649.12

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	1,308,640,649.12	1,308,640,649.12
512	Хуримтлагдсан үр дүн	-227,456,547.38	-3,578,568.82
51210	Өмнөх үеийн үр дүн	-227,456,547.38	-227,456,547.38
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	223,877,978.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	535,253,008.80	535,253,008.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,616,587,110.54	1,840,925,850.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

0	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	927,651,997.00	1,196,904,621.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,129,297.00	210,551,091.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,129,297.00	210,551,091.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,129,297.00	210,551,091.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,129,297.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,000,000.00	210,551,091.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	897,522,700.00	986,353,530.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	731,629,600.00	842,619,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	731,629,600.00	842,619,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,000,000.00	21,619,430.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,000,000.00	12,759,430.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	8,860,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	139,893,100.00	122,114,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	139,893,100.00	122,114,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	899,564,393.59	973,026,642.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	899,564,393.59	973,026,642.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	861,906,694.59	906,973,644.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	531,459,026.00	600,558,391.00
210101	Үндсэн цалин	484,288,439.00	567,696,969.00
210104	Урамшуулал	47,170,587.00	32,861,422.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,423,604.00	75,763,031.00
210201	Тэтгэврийн даатгал	67,423,604.00	51,480,978.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	5,621,617.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	3,545,710.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,075,837.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	14,038,889.00

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,158,844.00	117,022,992.00
210301	Гэрэл, цахилгаан	5,411,044.00	4,239,992.00
210302	Түлш, халаалт	127,691,800.00	111,727,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,056,000.00	1,056,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,858,773.94	9,911,795.00
210401	Бичиг хэрэг	1,559,640.00	2,733,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,714,800.00	4,408,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,520,185.00	759,277.00
210404	Ном, хэвлэл	29,400.00	54,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	73,400.00	509,268.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,389,400.00	1,204,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	14,571,948.94	242,800.00
2105	Нормативт зардал	31,872,810.00	20,842,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	418,900.00	726,900.00
210502	Хоол, хүнс	31,061,210.00	20,115,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	392,700.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,434,550.00	8,086,800.00
210604	Урсгал засвар	17,434,550.00	8,086,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,658,000.00	1,448,000.00
210702	Дотоод албан томилолт	1,658,000.00	1,448,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,615,800.00	4,767,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,215,800.00	2,067,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	2,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,425,286.65	68,572,835.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,748,015.00	3,355,699.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,522,500.00	3,323,622.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,154,771.65	61,893,514.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,657,699.00	66,052,998.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,478,562.00	28,738,330.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,309,580.00	14,289,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,759,430.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,168,982.00	1,689,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,860,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,860,000.00

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,203.00	163,808.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,203.00	163,808.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,177,934.00	31,290,860.00
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	770,000.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,407,934.00	31,290,860.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	28,087,603.41	223,877,978.56
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,029,689.79	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,029,689.79	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,029,689.79	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	22,057,913.62	223,877,978.56

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	898,651,997.00	986,353,530.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,129,297.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,129,297.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,129,297.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,129,297.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	897,522,700.00	986,353,530.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	731,629,600.00	842,619,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	731,629,600.00	842,619,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,000,000.00	21,619,430.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,000,000.00	12,759,430.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	8,860,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	139,893,100.00	122,114,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	139,893,100.00	122,114,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	898,651,997.00	986,353,530.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	898,651,997.00	986,353,530.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	861,196,838.00	922,199,712.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,608,495.00	600,050,781.00
210101	Үндсэн цалин	427,353,217.00	475,777,384.52

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	53,800,500.00	73,858,387.02
210104	Урамшуулал	46,454,778.00	50,415,009.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,454,299.00	75,389,548.00
210201	Тэтгэврийн даатгал	50,183,162.00	51,890,528.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,318,600.00	5,814,442.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,254,737.00	3,962,006.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,060,300.00	1,220,393.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,637,500.00	12,502,179.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,158,844.00	118,950,992.00
210301	Гэрэл, цахилгаан	5,411,044.00	5,239,992.00
210302	Түлш, халаалт	127,691,800.00	112,655,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,056,000.00	1,056,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,324,585.00	11,894,139.00
210401	Бичиг хэрэг	1,406,900.00	1,381,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,608,200.00	4,408,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,520,185.00	835,277.00
210404	Ном, хэвлэл	3,047,100.00	1,876,744.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	509,268.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,562,200.00	2,883,300.00
2105	Нормативт зардал	34,493,100.00	39,701,330.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	331,800.00	1,873,300.00
210502	Хоол, хүнс	32,899,600.00	19,570,030.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,261,700.00	18,258,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,304,300.00	36,695,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	16,200,000.00
210602	Тавилга	15,781,100.00	5,800,000.00
210604	Урсгал засвар	24,523,200.00	14,695,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,658,000.00	1,448,000.00
210702	Дотоод албан томилолт	1,658,000.00	1,448,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,913,300.00	8,701,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,513,300.00	4,001,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	4,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,281,915.00	29,368,322.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,333,415.00	7,548,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,948,500.00	21,820,072.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,455,159.00	64,153,818.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,046,022.00	26,839,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,487,040.00	12,389,920.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,759,430.00

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,558,982.00	1,689,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,860,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,860,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,203.00	163,808.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,203.00	163,808.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,407,934.00	31,290,860.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,407,934.00	31,290,860.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,270,640,649.12	335,342,731.00	27,599,579.83	1,633,582,959.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,270,640,649.12	335,342,731.00	27,599,579.83	1,633,582,959.95
C07	Тайлант үеийн үр дүн	38,000,000.00	00.00	-279,215,202.92	-241,215,202.92
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,308,640,649.12	535,253,008.80	-227,456,547.38	1,616,437,110.54
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,308,640,649.12	535,253,008.80	-227,456,547.38	1,616,437,110.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,308,640,649.12	535,253,008.80	-227,456,547.38	1,616,437,110.54
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	223,877,978.56	223,877,978.56
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,308,640,649.12	535,253,008.80	-3,578,568.82	1,840,315,089.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	964,612,400.00	933,279,432.00	31,332,968.00	96.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	964,612,400.00	933,279,432.00	31,332,968.00	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	944,195,500.00	919,199,712.00	24,995,788.00	97.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	614,116,200.00	600,050,781.00	14,065,419.00	97.7
210101	Үндсэн цалин	480,677,800.00	475,777,384.52	4,900,415.48	99.0
210102	Нэмэгдэл	79,065,900.00	73,858,387.02	5,207,512.98	93.4
210104	Урамшуулал	54,372,500.00	50,415,009.46	3,957,490.54	92.7

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,764,500.00	75,389,548.00	1,374,952.00	98.2
210201	Тэтгэврийн даатгал	51,893,000.00	51,890,528.00	2,472.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,208,100.00	5,814,442.00	393,658.00	93.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,910,900.00	3,962,006.00	948,894.00	80.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,250,200.00	1,220,393.00	29,807.00	97.6
210205	Эрүүл мэндийн даатгал	12,502,300.00	12,502,179.00	121.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,993,100.00	118,950,992.00	42,108.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,745,100.00	5,239,992.00	505,108.00	91.2
210302	Түлш, халаалт	112,192,000.00	112,655,000.00	-463,000.00	100.4
210303	Цэвэр, бохир ус	1,056,000.00	1,056,000.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,859,500.00	11,894,139.00	965,361.00	92.5
210401	Бичиг хэрэг	1,381,400.00	1,381,400.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	4,408,200.00	4,408,150.00	50.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,777,200.00	835,277.00	941,923.00	47.0
210404	Ном, хэвлэл	1,883,700.00	1,876,744.00	6,956.00	99.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	525,400.00	509,268.00	16,132.00	96.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,883,600.00	2,883,300.00	300.00	100.0
2105	Нормативт зардал	46,040,200.00	39,701,330.00	6,338,870.00	86.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,873,300.00	1,873,300.00	00.00	100.0
210502	Хоол, хүнс	25,908,900.00	19,570,030.00	6,338,870.00	75.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,258,000.00	18,258,000.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,998,100.00	36,695,000.00	303,100.00	99.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,500,000.00	16,200,000.00	300,000.00	98.2
210602	Тавилга	5,800,000.00	5,800,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	14,698,100.00	14,695,000.00	3,100.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,206,000.00	1,448,000.00	758,000.00	65.6
210702	Дотоод албан томилолт	2,206,000.00	1,448,000.00	758,000.00	65.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,951,600.00	5,701,600.00	250,000.00	95.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,001,600.00	1,001,600.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,950,000.00	4,700,000.00	250,000.00	94.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30266300.00	29368322.00	897,978.00	97.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	7,548,250.00	451,750.00	94.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,266,300.00	21,820,072.00	446,228.00	98.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20416900.00	14079720.00	6,337,180.00	69.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,416,900.00	14,079,720.00	6,337,180.00	69.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,458,000.00	12,389,920.00	6,068,080.00	67.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,958,900.00	1,689,800.00	269,100.00	86.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	964,612,400.00	933,279,432.00	31,332,968.00	96.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	842,619,300.00	811,328,440.00	31,290,860.00	96.3
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	842,619,300.00	811,328,440.00	31,290,860.00	96.3

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	121,993,100.00	121,950,992.00	42,108.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	121,993,100.00	121,950,992.00	42,108.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	54	54	0	
620001	Удирдах ажилтан	4	4	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	31	31	0	
620003	Үйлчлэх ажилтан	19	19	0	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	490	476	14	
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	490	476	14	
630001	Төрийн өмчит ЕБС	490	476	14	

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
21	УРСГАЛ ЗАРДАЛ		21,619,430.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		12,759,430.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		5,860,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	21619430.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		21,619,430.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,759,430.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		8,860,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал С.Цэгмид танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-аас 2021 оны 02 дугаар сарын 17-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл хариуцаж хэрэгжүүлэв.

Галуут сумын Ерөнхий боловсролын нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 69 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг бага, суурь, бүрэн дунд боловсролыг хамран тойрох багийн хүүхдүүд, иргэдэд тэгш олгож, боловсрол эзэмшүүлэх, сургалт болон соёл хүмүүжлийн ажил, олон нийтийн оролцоог тулгуурлан чанар хүртээмжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бүрдүүлэн үдийн цайгаар үйлчлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас 2020 оны 4 дүгээр улирлын хамруулан шалгалт хийжээ. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 636202.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12724.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 973026.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 19460.5 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,840,925.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 224,338.7 мянган төгрөгөөр буюу 13.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,179.4	120,374.5	49,195.1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	441.3	12,860.7	12,419.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	70,738.1	107,513.9	36,775.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,545,407.7	1,720,551.3	175,143.6
Үндсэн хөрөнгө	1,730,391.1	1,967,428.2	237,037.1
Хуримтлагдсан элэгдэл	(184,983.4)	(246,876.9)	(61,893.5)
Нийт хөрөнгө	1,616,587.1	1,840,925.9	224,338.7
Өр төлбөр	150.0	610.8	460.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,616,437.1	1,840,315.1	223,878.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,616,587.1	1,840,925.9	224,338.7

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 12860,7 мянган төгрөг болж 12419.4 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст сургалтын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор 9885,0 мянган төгрөгийн

өртөг бүхий ухаалаг самбарыг авахаар “Дэвших болор” ХХК руу шилжүүлсэн бөгөөд хөрөнгийг тайлант онд хүлээн аваагүй учир санхүүгийн тайланд авлагаар тусгасан нь голлох нөлөөг үзүүлж байна. Мөн жилийн эцэст “Эко дулаан” ХХК руу халаалтын зардлыг 980.0 мянган төгрөгөөр илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 107513.9 мянган төгрөг болж 36775,8 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар ахуйн материал дээр 29014.2 мянган төгрөгийн зөөлөн эдлэл бусад материал авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1967428,2 мянган төгрөг болж 237037,1 мянган төгрөгөөр өссөн нь сургуулийн урлагийн заалны засварын ажлыг 166164,7 мянган төгрөгийн өртгөөр засварласан байна. Мөн БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 3586352 төгрөгийн зөөврийн компьютер, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 7000,0 мянган төгрөгийн өртөгтэй цэвэр бохир усны шугам, Бүгд найрамдах Солонгос улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /KOICA/-ын санхүүжилтээр 24000,0 мянган төгрөгийн гүний өрмийн худаг, урсгал төсвийн худалдан авалтаар 26486.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1840315,1 мянган төгрөг болж 223878,0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 223878,0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1196904,6 мянган төгрөг болж, өмнөх оноос 269252.6 мянган төгрөгөөр буюу 29 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үнэ төлбөргүй авсан орлого байна. Үнэ төлбөргүй авсан орлого 181551,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Нийт зардал 973026,6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 73462,2 мянган төгрөгөөр буюу 7,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 69099.4 мянга, төвлөрүүлэх шилжүүлэг 31332.7 мянга буюу 31290.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 881655,3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 881655,3 мянган төгрөгөөр тооцон суралцагчдын тоог 493, ажиллагсдыг 55 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 74850,3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж анх 56505,6 мянган төгрөгөөр баталж 2 удаагийн зохицуулалт хийж 964612,4 мянган төгрөгөөр баталсан байна. Суралцагчдын тоог 576, ажиллагсдыг 54 орон баталсан байна. Цалин, НДШ-ын зардлыг бууруулан бараа үйлчилгээний бусад зардал, эд хогшил худалдан авах зардлыг нэмэгдүүлж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 964612,4 мянган төгрөгийн төсөв баталснаас 842619,3 мянган төгрөгийг

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 121993,1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 842619,3 мянга, орон нутгийн төсвөөс 121993,1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 933279,4 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 31290,9 мянга, орон нутгийн төсөвт 42,1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 933279,4 мянган төгрөг буюу 96,8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 14065,4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 42,1 мянга, хангамж бараа материалын зардлыг 965,4 мянга, НДШ зардлыг 1374,9 норматив зардлыг 6338,9 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 303,1 мянга, томилолт зочны зардлыг 758,0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 250,0 мянга, бараа үйлчилгээний зардлыг 897,9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Энэ нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хэрэгсэл халдвар хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэх бодис, сургалтын үйл ажиллагааг зогсоосон зэргээс шалтгаалжээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 31332,9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээний зардлыг 31332,9 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт-2 Төсвийн гүйцэтгэлийн бүлэгтэй

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	964,612,400.0	933,279,432.0	31,332,968.0	96.8
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	964,612,400.0	933,279,432.0	31,332,968.0	96.8
АРГА ХЭМЖЭЭ 80109 тогтмол зардал	-	-	-	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,993,100	121,950,992	163,808	99.8
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	-	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг	1,958,900	1,689,800	269,100	86.2
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81801 үдийн цай хөтөлбөр	-	-	-	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,458,000	12,389,920	6,068,080	67.1
Бусад урсгал шилжүүлэг	18,458,000	12,389,920	6,068,080	67.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,458,000	12,389,920	6,068,080	67.1
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81806 Дотуур байр	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	107,229,100	100,327,367	6,901,733	93.5
Бараа, үйлчилгээний зардал	107,229,100	100,327,367	6,901,733	93.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,489,100	63,415,037	74,063	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,981,100	7,852,300	128,800	98.4
Хангамж, бараа материалын зардал	697,200	697,200	0	100.0
Норматив зардал	33,805,300	27,466,430	6,338,870	81.2
Эд хогшил худалдан авах	896,400	896,400	0	100.0
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81834 Боловсролын стандарт, сургалтын хэвийн орчин	-	-	-	-

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	518,990,600.0	503,685,076.8	15,305,523.2	96.9
Бараа, үйлчилгээний зардал	518,990,600.0	503,685,076.8	15,305,523.2	96.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,363,100.0	380,683,656.8	11,679,443.2	96.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,188,500.0	45,402,033.0	786,467.0	98.3
Хангамж, бараа материалын зардал	6,928,700.0	6,298,165.0	630,535.0	90.9
Норматив зардал	12,234,900.0	12,234,900.0		100.0
Эд хогшил худалдан авах	33,101,700.0	32,798,600.0	303,100.0	99.0
Томилолт, зочны зардал	2,341,200.0	1,448,000.0	893,200.0	61.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,951,600.0	5,701,600.0	200,000.0	95.8
Бараа үйлчилгээний бусад зардал	20,016,100.0	19,118,122.0	897,978.0	95.5
ХӨТӨЛБӨР 71802	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 81835 сургалтын хэвийн ажиллагаа	-	-	-	-
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	172,430,000.0	171,038,938.2	1,391,061.8	99.2
Бараа, үйлчилгээний зардал	172,430,000.0	171,038,938.2	1,391,061.8	99.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,190,700.0	136,518,349.2	672,350.8	99.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,005,700.0	19,648,539.0	357,161.0	98.2
Хангамж, бараа материалын зардал	5,233,600.0	4,872,050.0	361,500.0	93.1
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.0	10,000,000.0	0	100
ХӨТӨЛБӨР 71806 Насан туршийн боловсрол	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 80101 сургалтын хэвийн ажиллагаа	-	-	-	-
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	23,552,700.0	22,197,338.0	1,355,362.0	94.2
Бараа, үйлчилгээний зардал	23,552,700.0	22,197,338.0	1,355,362.0	94.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,713,300.0	19,433,738.0	1,279,562.0	93.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,589,200.0	2,513,400.0	75,800.0	97.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага х	250,000.0	250,000.0	0	100

Эх сурвалж: Төсвийн хэлбэлзлийн хөтөлбөртэй тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 128

Хүснэгт 3: Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа нь болоогүй мэдээлэл	Байршуул аагүй
1	Бүтэн жил	11	11	9		2	
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	34	2		
5	Тухай бүр	8	96	78	9		9
6	Нийт	27	151	129	11	2	9

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас

мэдээлэл, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл, тухай бүр мэдээлэх мэдээллээс 2,11 дүгээр дүгээр саруудад 12239.7 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, 10,11,12 дугаар саруудад

50805.9 мянган төгрөгийн зарлагын 7 гүйлгээ, нийт 63045,7 мянган төгрөгийн 9 гүйлгээг тус тус мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;"- д заасныг зөрчиж байгаа тул зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2450.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг 2020.09.30-ны төлж барагдуулсан байна.

Хүснэгт 4: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2450.0	1	2450.0	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	2450.0	1	2450.0	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Тайлант онд аудитаар нийт 13503.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 928.0 төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах албан шаардлага 1, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 12575.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Байхгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 13503.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 928.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийн арилгах албан шаардлага 1 хүргүүлж ажиллаа. Үүнд:

1. Эко дулаан ХХК-аас 111,727.0 мянган төгрөгийн халаалтын зардлын нэхэмжлэх ирсэн байхад 112,655.0 мянган төгрөгийг шилжүүлэн илүү төлсөн 928.0 мянган төгрөгийг авлага үүсгэн төсвийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчиж, санхүүгийн тайлагналын "Хэмжилт", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эко дулаан ХХК-руу илүү шилжүүлсэн 928.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Шилэн дансны тухай Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 151 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 129, хугацаа хоцроосон 11, хугацаа болоогүй 2, байршуулаагүй 9 мэдээлэл байна.

Шилэн дансны хуулийн дагуу байршуулах мэдээллээс хугацаа хоцроосон 11 мэдээлэл нь төсвийн гүйцэтгэл 2, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар 1, Тухай жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 1, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ 2, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 5, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт 1 тус тус хоцорсон байна.

Шилэн дансны тухай хуулийн хүрээнд байршуулаагүй 9 мэдээлэл нь цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2, 11 дүгээр сарын 12239.9 мянган төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 10,11,12 дугаар саруудын 50805.9 мянган төгрөгийн 7 гүйлгээг шилэн дансны цахим хуудаст тус тус байршуулаагүй байгаа нь санхүүгийн тайлагналын "Иж бүрэн байх", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан мэдээллүүдийг үнэн зөв, иж бүрэн байршуулж, зөрчлийг арилгах **албан шаардлага** хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 12575.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацааны цалингийн зардлаас бусад бүх гүйлгээг анхан шатны баримтаас хөөн шалгахад е-баримтгүй 2074.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

1.3 Өгсөн зөвлөмж: Цаашид аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс худалдан авалт хийхдээ дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлүүлж авах болон Е-баримт.mn сайтаар өөрийн байгууллагын нэр регистрээр шивүүлж, худалдан авалтад тавих хяналтыг сайжруулах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Аймгийн БСУГ-ын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар ЕБС-дад "хичээл практик"-ийн зардлыг 10000,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүний дагуу "Дэвших болор" ХХК -руу сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885,0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийг хүлээж аваагүй учраас авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: "Дэвших болор" ХХК-аас хөрөнгийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулах, "Ковид-19" цар тахлын улмаас хэмнэгдэж буй зардлыг үр ашигтай зарцуулж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж өр авлага үүсгэхгүй ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Няравын тайланг бараа материалын орлого, зарлагын журналтай тулгахад үдийн цайны 3 менюг, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний минуттай нийлүүлж үдсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

3.3. Өгсөн зөвлөмж: Цаашид бараа материалыг орлого авах, зарлага гаргахдаа анхан шатны баримтын бүрдлийг шалгаж, түүнд үндэслэж нягтлан бодох бүртгэлийг хөтлөх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл нь санхүүгийн тайланд 525253.0 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 234727.2 мянган төгрөг, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дахин үнэлгээний нэгтгэлд 222715.7 мянган төгрөг буюу нийт 300525.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.44. "Дахин үнэлгээний

Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн данс руу шилжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

4.2. Эрсдэл: Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

4.3. Өгсөн зөвлөмж: Цаашид 2018 оноос өмнөх онуудад хийгдсэн дахин үнэлгээний тайлангийн мэдээллийн дагуу дахин үнэлгээ дансны бүртгэлийг залруулах зөвлөмж өгөв.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ
ОГНОО: 2021.02.18

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.18

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.18



Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Галуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			Аудитын код: БНА-2021/99/СТА-ТШЗ	
2020						
Шалгагдсан байгууллагын нэр:		Галуут сумын Ерөнхий боловсролын сургууль			Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны		
			Нэр	Албан тушаал	Овог нэр	
A	1	2	3	4	5	
1	Эко дулаан ХХК-аас 111,727.0 мянган төгрөгийн халаалтын зардлын нэхэмжлэх ирсэн байхад 112,655.0 мянган төгрөгийг шилжүүлэн илүү төлсөн 928.0 мянган төгрөгийг авлага үүсгэн төсвийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлээгүй байна.	928.0	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Цэгмид, С.Ариунжаргал	
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2,11 дүгээр дүгээр саруудад 12239.7 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, 10,11,12 дугаар саруудад 50805.9 мянган төгрөгийн зарлагын 7 гүйлгээ, нийт 63045,7 мянган төгрөгийн 9 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	0	Албан шаардлага	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Цэгмид, С.Ариунжаргал	
3	Тайлант хугацааны цалингийн зардлаас бусад бүх гүйлгээг анхан шатны баримтаас хөөн шалгахад е баримтгүй 2074.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ байна.	2074.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Цэгмид, С.Ариунжаргал	
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл нь санхүүгийн тайланд 525253.0 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 234727.2 мянган төгрөг, аймгийн "Орон нутгийн өмчийн газрын дахин үнэлгээний нэгтгэлд 222715.7 мянган төгрөг буюу нийт 300525.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Цэгмид, С.Ариунжаргал	
5	Няравын тайланг бараа материалын орлого, зарлагын журналтай тулгахад үдийн цайны 3 менюг, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний менютэй нийлүүлж үдсэн зөрчил илэрлээ.	616.2	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Цэгмид, С.Ариунжаргал	
6	Аймгийн БСУГ-ын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар ЕБС-дад "хичээл практик"-ийн зардлыг 10000,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүний дагуу "Дэвших болор" ХХК -руу сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885,0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийг хүлээж аваагүй учраас авлагаар тусгасан байна.	9885.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	С.Цэгмид, С.Ариунжаргал	
ДҮН		13503.2				